

Сайн байна уу,  
Аргентинаас  
мэндчилж байна!



Импанадас бол Аргентины алдартай хоол юм. Энэ нь нарийн боовны гуриланд ороосон үхрийн мах, эрдэнэ шиш юм уу жимс байдаг. Янзтай!

Аргентинд ягуар, аварга тас шувуу, оцон шувуу гээд олон сонирхолтой амьтан амьдардаг.



Сайн уу?  
Биднийг  
Марго, Паоло  
гэдэг.



Бидэнтэй  
хамт Арген-  
тинаар  
аялна уу!



ЗУРАГ ЧИМЭГЭЛЭЙГ КЭТИ МАКДИЙ



Олон хүн задгай  
захаас хоол хүнсээ  
худалдан авдаг.  
Энэ хүү аавдаа  
сандиа буюу ший-  
гуа авч явахад нь  
тусалж байна.



Ушуаиа бол дэлхийн өмнөд туйлтай хамгийн ойрхон оршдог хотуудын нэг юм. Тэр хотод гурван тойрог бий.



Аргентинд ковбойчуудыг гаучос гэж нэрлэдэг. Тэд үхэр, адуу малладаг.



Энэ охин Аргенти-  
ны Кордоба ариун  
сүмийг онцгойлон  
адислагдсан өдөр  
тэнд очжээ. Удахгүй  
Аргентин гурван  
ариун сүмтэй болно!



Зарим аргентин найзтай  
минь танилцана уу!



Ерөнхийлөгч Нэлсоныг хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан зорилгууд бүхий шинэ хөтөлбөрийг танилцуулах үед би гүйх, сайн найз байх, илүү сайн залбирдаг болох гэсэн зорилго тавьсан. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлбэл Тэнгэрлэг Эцэг надад тусална гэдгийг мэднэ гэсэн гэрчлэлээ би ариун ёслол дээр хэлсэн.

Гонзало Л., 7 настай,  
Аргентины Буэнос Айрес хот



Бид судар уншихдаа, Есүс Христийн тухай болон Тэр биднийг хэрхэн хайрлагдгийг сурч мэддэг. Энэ нь намайг аз жаргалтай байхад тусалдаг. Тэр надад хайртайг би мэднэ.

Эмма Л., 5 настай,  
Аргентин, Буэнос Айрес хот

Та Аргентинаас ирсэн үү? Бидэнд захидал бичээрэй! Бид таны хариуг хүлээж байна.

Аргенти-  
наар бидэнтэй  
хамт аялсанд баяр-  
лалаа! Дараа дахин  
уулзацгаая!

